

**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ТУРШИЛТ, ЗОХИОН БҮТЭЭХ АЖИЛ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл .....	2
Хоёрдугаар бүлэг. Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын судалгааны үндсэн чиглэлийг санхүүжүүлэх.....	4
Гуравдугаар бүлэг. Төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх.....	5
Нэг. Төсөл захиалах .....	5
Хоёр. Төслийг зарлах .....	6
Гурав. Төслийг боловсруулах, мэдүүлэх .....	7
Дөрөв. Шинжээч томилох, төслийг сонгон шалгаруулах, батлах .....	7
Тав. Төсөл хэрэгжүүлэх гэрээ байгуулах, санхүүжүүлэх.....	9
Зургаа. Төслийн хэрэгжилтэд хяналт тавих .....	10
Дөрөвдүгээр бүлэг. Эрдэм шинжилгээний ажлын үр дүн, түүнийг хүлээн авах, баталгаажуулах, мэдээлэх, тайлагнах .....	11
Тавдугаар бүлэг. Хариуцлага .....	12

## ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ТУРШИЛТ, ЗОХИОН БҮТЭЭХ АЖИЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

### Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү журмын зорилго нь эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг гүйцэтгэх, түүний үр дүнг үйлдвэр, үйлчилгээнд туршиж, зүгшрүүлэх үйл ажиллагааны үндсэн зарчмыг тогтоох, түүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
2. Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг дараах хэлбэрээр санхүүжүүлнэ:
  - 2.1. Шинжлэх ухаан технологийн тухай хуулийн 16.4-т заасны дагуу төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын судалгааны үндсэн чиглэлийг тогтоож, санхүүжүүлэх;
  - 2.2. Нээлттэй, чөлөөт өрсөлдөөний зарчмаар шинжлэх ухаан, технологийн төсөл /цаашид “төсөл” гэх/ сонгон шалгаруулж, санхүүжүүлэх;
3. Энэ журамд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно.
  - 3.1. “Судалгааны үндсэн чиглэл” гэж төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын голлох судлагдахуунд хамаарах эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг;
  - 3.2. “Захиалагч” гэж тулгамдсан асуудлаа шинжлэх ухааны үндэслэлтэйгээр шийдвэрлүүлэхээр шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад санал ирүүлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэнийг;
    - 3.2.1. Энэ журмын 7.2, 7.4-т заасан төслийн хувьд шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага захиалагч байна.
  - 3.3. “Гүйцэтгэгч” гэж төслийг хэрэгжүүлэх үүргийг гэрээгээр хүлээсэн этгээдийг;
  - 3.4. “Суурь судалгааны санаачлагын төсөл” гэж Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 3.1.3-д заасан судалгааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн баримт бичгийг;
  - 3.5. “Улсын захиалгат шинжлэх ухаан, технологийн төсөл” гэж Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэх, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ болон төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тулгамдсан асуудлыг судалж

- шийдвэрлэхээр боловсруулсан Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 3.1.8-д заасан баримт бичгийг;
- 3.6. “Туршилт, зүгшрүүлэлтийн төсөл” гэж Инновацийн тухай хуулийн 3.1.9-д заасан эрдэм шинжилгээний ажлын үр дүнд бий болсон эрхийн хамгаалалт хийгдсэн оюуны бүтээлийг үйлдвэрлэл, үйлчилгээнд турших, сайжруулах, шинэчлэх, нутагшуулах болон техник, технологийн баримт бичгийг бүрдүүлэх, түүнийг нэвтрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөсөн баримт бичгийг;
  - 3.7. “Гадаадтай хамтарсан төсөл” гэж шинжлэх ухаан, технологийн салбарт хамтран ажиллах талаархи Засгийн газар хоорондын хэлэлцээр, хоёр болон олон талт хамтын ажиллагааны гэрээний хүрээнд хэрэгжүүлэх баримт бичгийг;
4. Шинжлэх ухаан, технологийн төсөл гүйцэтгэхтэй холбоотой хууль, тогтоомж, дүрэм, журам
  5. Төсөл хэрэгжүүлэхэд баримтлах зарчим
    - 5.1. шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хамаарах төслийг тэргүүн ээлжинд сонгон хэрэгжүүлэх
    - 5.2. үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцсэн байх;
    - 5.3. зах зээлийн эрэлт хэрэгцээнд суурилсан байх;
    - 5.4. үр дүнд суурилсан байх;/үр ашигтай байх;
    - 5.5. өрсөлдөх тэгш боломжтой байх;
  6. Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаа дараахь үе шаттай байна.
    - 6.1. захиалах, нээлттэй зарлах
    - 6.2. боловсруулах; мэдүүлэх
    - 6.3. гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах;
    - 6.4. гэрээ байгуулж баталгаажуулах;
    - 6.5. санхүүжүүлэх;
    - 6.6. гүйцэтгэлд хяналт тавих;
    - 6.7. үр дүнг мэдээлэх, тайлагнах, баталгаажуулах;
    - 6.8. үр дүнг хүлээлгэн өгөх, санхүүгийн тооцоо хийх.
  7. Төсөл нь дараах төрөлтэй байна:
    - 7.1. Улсын захиалгат шинжлэх ухаан, технологийн төсөл;
    - 7.2. Суурь судалгааны санаачлагын төсөл;
    - 7.3. Технологийн туршилт, зүгшрүүлэлтийн төсөл;
    - 7.4. Гадаадтай хамтарсан төсөл
  8. Төслийн гүйцэтгэгч нь дор дурдсан этгээд байна:
    - 8.1. Шинжлэх ухаан, технологийн тухай хууль 11.2-т заасан эрдэм шинжилгээний байгууллага;
    - 8.2. аж ахуйн нэгж, байгууллага;

- 8.3. судлаачдынбаг;
- 8.4. Монгол Улсын болон гадаадын иргэн, харъяалалгүй этгээд.
9. Төслийн уралдаанд төслийн удирдагч багаа бүрдүүлэн өрсөлдөнө.Удирдагч нь төслийн багийгарга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, төсөлд зориулсан хөрөнгийг зохих журмын дагуу зарцуулах, эцсийн үр дүнгийн захиалагчийн өмнө хариуцах үүрэгтэй. Үүргээ хангалтгүй биелүүлсэн болон хүндэтгэн үзэх шалтгаанаар төслийн удирдагчийг сольж болно. Төслийн удирдагчийг солих шийдвэрийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага захиалагчтай хамтран гаргана.
- 10.Удирдагч нь докторын зэрэгтэй, судалгааны чиглэлээрээ сүүлийн 4 жил тодорхой амжилт гаргасан байх, тасралтгүй 2 жил ажилласан байна.
- 11.Төслийн баг нь удирдагч, үндсэн судлаач, гишүүдээс бүрдэх бөгөөд 10 хүртэл хүний бүрэлдэхүүнтэй байж болно. Төслийн багийн бүрэлдэхүүний 50-аас доошгүй хувь ньэрдэм шинжилгээний ажилтан байна.Төслийн удирдагч үндсэн судлаачийг тогтвор суурьшилтай ажиллуулна.
- 12.Эрдэм шинжилгээний ажилтан, судлаач 2 хүртэлх төсөлд удирдагч эсхүл гүйцэтгэгчээр ажиллаж болно.
- 13.Энэхүү журмын 12 дахь заалт нь гадаадтай хамтарсан төсөл хамаарахгүй.
- 14.Төсөл хэрэгжүүлэх хугацаа 3 хүртэл жил байна.Шинэ эм, эмчилгээний технологи, ургамлын сорт, малын шинэ үүлдэр зэрэг үр дүнг гарган авах төслийн хугацаа 5 хүртэл жил байж болно.

### **Хоёрдугаар бүлэг. Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагынсудалгааны үндсэн чиглэлийг санхүүжүүлэх**

- 15.Эрдэм шинжилгээний байгууллагын судалгааны үндсэн чиглэлийг Шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага тогтооно.Эрдэм шинжилгээний байгууллага“Үр дүнгийн гэрээ”-нд тусгагдсан сэдвээр энэ журмын 7-д заасан төслийн сонгон шалгаруулалтад оролцохыг хориглоно.
- 16.Энэ журмын 15 дугаар заалт нь Шинжлэх ухаан, технологийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцаас санхүүждэг эрдэм шинжилгээний байгууллагад хамаарна.
- 17.Судалгааны үндсэн чиглэлийг шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологи, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улс орны эдийн засаг, нийгмийн хэрэгцээ шаардлага, шинжлэх ухааны хөгжлийн олон улсын чиг хандлага зэрэгт үндэслэн 4 жил тутамд тодотгоно.
- 18.Эрдэм шинжилгээний байгууллагын санхүүжилтийн хувь хэмжээг түүнийшинжлэх ухаан, технологийн чадавхи, үйл ажиллагааны түвшний

үнэлгээ, зэрэглэлийгүндэслэншинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

19. Эрдэм шинжилгээний байгууллага судалгааны үндсэн чиглэлийн үйл ажиллагаагаа Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасан “Үр дүнгийн гэрээ”-нд тусган хэрэгжүүлэх бөгөөд энэ хуульд заасны дагуу хяналт тавьж тайлагнана.
20. Судалгааны ажлын үр дүнг хүлээлгэн өгөх, баталгаажуулахтай холбогдсон харилцааг дөрөв, хүлээх хариуцлагыг тавдугаар бүлгээр зохицуулна.
- 21.

## Гуравдугаар бүлэг. Төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх

### Нэг. Төсөл захиалах

22. ШУТУЗ жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор ирэх онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны нэгдсэн хөтөлбөрийг хэлэлцэж, эрдэм шинжилгээний зардлын хуваарийг төслийн төрөл болон салбар тус бүрээр тогтооно.
23. Энэ журмын 20-д заасан хуваарийг үндэслэн захиалагч яамдад оногдох хөрөнгийн хэмжээ, төслийн тооны хязгаарыг шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага тогтоож, хүргүүлнэ.
24. Улсын захиалгат шинжлэх ухаан, технологийн төслийн үр дүнгийн захиалгын саналыг дор дурьдсан дарааллаар зохион байгуулна:
  - 24.1. Захиалагч жил бүрийн 2 дугаар сарын 1-ний дотор энэ журмын 21 дүгээр зүйлд заасан зардлын хуваарьт багтаан ирэх оноос эхлэн хэрэгжүүлэх төслийн үр дүнгийн захиалгын саналаа шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.
  - 24.2. Үр дүнгийн захиалгын санал нь дор дурдсан бүрдэлтэй байна:
    - 24.2.1. үр дүнгийн эрэлт хэрэгцээ, шаардлага, шийдвэрлэх асуудал, үндэслэл
    - 24.2.2. хүлээн авах үр дүнгийн жагсаалт
    - 24.2.3. үр дүнгийн шалгуур үзүүлэлт
    - 24.2.4. үр дүнг хүлээж авах хугацаа;
    - 24.2.5. нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологийн ач холбогдол;
    - 24.2.6. захиалагчаас гаргах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн хэлбэр;

- 24.2.7. үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх бодлого, ашиглахад шаардагдах зардлын урьдчилсан тооцоо, түүний эх үүсвэрийг шийдвэрлэх арга зам;
- 24.2.8. үр дүнг нэвтрүүлж ашигласнаас олох эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын төсөөлөл;
- 24.2.9. Төслийн захиалгын саналыг хэлэлцсэн салбарын яамны шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлын шийдвэр, тэмдэглэл.
- 24.3. Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөл Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 7.1.2-т заасны дагуу төслийн үр дүнгийн захиалгын саналыг хэлэлцэн зөвлөмж гаргана.
- 24.4. Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөл төслийн үр дүнгийн захиалгын саналын талаар зөвлөмж гаргахдаа дор дурдсан шалгуур, шаардлагыг үндэс болгоно:
  - 24.4.1. Энэ журмын 21-д заасан санхүүжилтийн хуваарьт багтсан байх
  - 24.4.2. Энэ журмын 5-д заасан зарчмыг баримталсан байх
  - 24.4.3. төслийг хэрэгжүүлэх эдийн засаг, нийгмийн хэрэгцээ, шаардлага байгаа эсэх;
  - 24.4.4. төслийг өөрийн орны эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтдийн хүчээр хэрэгжүүлэх боломж;
  - 24.4.5. төсөл хэрэгжих магадлал /гүйцэтгэх багийн чадавхи; лаборатори, туршилтын баазын боломж/
  - 24.4.6. төслийн үр дүнг ашиглах боломж, нэвтрүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийн тооцоо;
  - 24.4.7. төслийг хэрэгжүүлэх хугацаа бодитой эсэх;

## Хоёр. Төслийг зарлах

- 25. Шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаэнэ журмын 7.1-д заасан төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тухай зарыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор зарлана.
- 26. Энэ журмын 7.2-т заасан төслийг сонгон шалгаруулах зарыг жил бүрийн 9 дүгээр сарын 01-ний дотор зарлана.
- 27. Энэ журмын 7.3-т заасан төслийг “Технологийн туршилт, зүгшрүүлэлтэд грант олгох журам”-д, 7.4-т заасан төслийг хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээрт заасан нөхцлийн дагуу зарлана.
- 28. Шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын цахим хуудсаар, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ. Зарыг өдөр тутмын сонин, Шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан

төрийн захиргааны төв байгууллагын цахим хуудсанд 30-аас доошгүй хоног байрлуулна.

### Гурав. Төслийг боловсруулах, мэдүүлэх

29. Төслийг зарын дагуу боловсрууланцахим хэлбэрээр мэдүүлж, бүртгэлийн дугаар авна. Мэдүүлсэн төслөө бүртгэлийн дугаараар баримтжууланхэвлэмэл хэлбэрээр 3 хувь үйлдэн, нотлох баримтын хамтаартовлосон хугацаанд шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаирүүлнэ. Хугацаа хоцорч ирсэн материалыг хүлээн авахгүй.
30. Сонгон шалгаруулалтад зөвхөнбүртгэлийн дугаарыг ашиглана.
31. Төслийн цахим хэлбэрээр мэдүүлэх, мэдүүлгийн санг бүрдүүлэх ажлыг Шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна.

### Дөрөв. Шинжээч томилох, төслийг сонгон шалгаруулах, батлах

32. Төслийн гүйцэтгэгчийг шинжээчийн багийн дүгнэлтэд үндэслэн сонгон шалгаруулна.
33. Шинжээчийг сонгон шалгаруулах журам, ёс зүйн дүрмийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
34. Төсөлд хянан магадлагаа хийхээр сонгогдсон шинжээчийн багийн бүрэлдэхүүнийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
35. Шинжээчийн мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг Шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна. Шинжээчийг сонгон шалгаруулах урилгыг жил бүр хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарласны үндсэн дээр шинжээчийн мэдээллийн санг баяжуулж, шинэчилнэ.
36. Шинжээчийн баг нь төслийн саналд үнэлгээ өгч, дүгнэлт гаргахдаа шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан аргачлалыг мөрдөнө.
37. Шинжээч энэ журмын 7.1-д хамаарах төслийн саналд тухайн оны 4 дүгээр сарын 15-ны дотор үнэлгээ хийж дүгнэлт гаргана. Дүгнэлт гаргахдаа дор дурдсан шалгуур үзүүлэлтийг баримтална:
  - 37.1. үр дүн нь захиалагчийн шаардлагыг хангасан байдал;
  - 37.2. захиалгат үр дүнгийн төсөөлөл бодитой эсэх;
  - 37.3. судалгааны онол, арга зүйн үндэслэл оновчтой эсэх;
  - 37.4. лаборатори, туршилт сорилтын баазын хангамж, түвшин;
  - 37.5. үр дүнгийн шинэлэг дэвшилттэй тал, түүнийг орлуулан хэрэглэж болох өөр бүтээгдэхүүн, технологи байгаа эсэх;

- 37.6. үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх боломж, эдийн засгийн үр ашгийг тодорхойлсон байдал;
38. Шинжээч энэ журмын 7.2-т хамаарах төслийн саналд тухайн оны 11 дүгээр сарын 01-ний дотор үнэлгээ хийж дүгнэлт гаргана. Дүгнэлт гаргахдаа дор дурдсан шалгуур үзүүлэлтийг баримтална:
  - 38.1. шинжлэх ухааны түвшин;
  - 38.2. үр дүнгийн дэлхийн шинжлэх ухаанд оруулж буй хувь нэмэр;
  - 38.3. шинэлэг байдал ;
  - 38.4. судалгааны арга зүй оновчтой, шинэлэг эсэх;
  - 38.5. зорилго ба зорилт тодорхой эсэх;
  - 38.6. төслийн удирдагчийн сүүлийн 3 жилд эшлэлийн системд /номзүйн мэдээллийн сан Web of Science, Web of Knowledge, Scopus, Astrophysics, PubMed, Mathematics, Chemical Abstracts, Springer, Agris, GeoRef, Оросын Шинжлэх ухаан мэдээллийн төв / ордог олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлд нийтлүүлсэн өгүүллийн тоо;
  - 38.7. төслийн хамтлагийн судалгааны сэдвийн хүрээнд олон улсын эшлэлийн системд /номзүйн мэдээллийн сан, тухайлбал Web of Science, Web of Knowledge, Scopus, Astrophysics, PubMed, Mathematics, Chemical Abstracts, Springer, Agris, GeoRef, Оросын Шинжлэх ухаан мэдээллийн төв/ багтдаг олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлд нийтлүүлсэн өгүүллийн тоо;
  - 38.8. лаборатори, туршилт сорилтын баазын хангамж, түвшин;
39. Энэ журмын 7.3-т хамаарах төслийг “Технологийн туршилт, зүгшрүүлэлтэд грант олгох журам”-аар сонгон шалгаруулна.
40. Энэ журмын 7.4-т хамаарах төслийн монголын талын гүйцэтгэгчийг энэхүү журмаар сонгон шалгаруулна.
41. Шинжээч өөрийн хүсэлтээр хянан магадлагаа хийхээс татгалзсан тохиолдолд өөр шинжээч томилно.
42. Шинжээч энэ журмын 35, 36-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэлт гаргаж, төслийг дэмжих эсэхээ тодорхой тусгасан байна.
43. Шинжээчийн дүгнэлтээр дэмжигдсэн төслийг нэгтгэн жил бүрийн 5 дугаар сарын 01-ний дотор Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлж, зөвлөмж гаргуулна. Зөвлөмжийг үндэслэн хэрэгжүүлэх төслийн жагсаалтыг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
44. Шинжээчийн дүгнэлтээр дэмжигдсэн, журмын 7.4-т хамаарах төслийг хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн дагуу Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр байгуулсан хамтарсан ажлын хэсэг хэлэлцэж нэгдсэн дүгнэлт гаргана.
45. Төслийн санхүүгийн тооцоо бодитой эсэх, гүйцэтгэгчдийн судалгааны чадавхи, туршлага, бусад сангийн санхүүжилтээр төсөл хэрэгжүүлэхдээ зөрчил гаргасан эсэх зэрэгт ШУТС үнэлгээ хийж, ажлын хэсэгт танилцуулна.



Шинжлэх ухаан, технологийн сан төслийн төсөвт өртөг, зардлыг тооцоолохзаавар боловсруулж, мөрдүүлнэ.

46. Ажлын хэсгийн нэгдсэн дүгнэлтийг үндэслэн шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 8.1.3-т заасны дагуу ирэх онд шинээр эхлэн хэрэгжүүлэх төслийн гүйцэтгэгчдийг баталгаажуулна.
47. Батлагдсан төсөл, төслийн гүйцэтгэгчдийн жагсаалтыг шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын цахим хуудсанд байрлуулж нийтэд мэдээлнэ.

### Тав. Төсөл хэрэгжүүлэх гэрээ байгуулах, санхүүжүүлэх

48. Төсөл, төслийн гүйцэтгэгчийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар батлагдснаас хойш захиалагч, санхүүжүүлэгч, гүйцэтгэгч (цаашид “талууд” гэх) нь үлгэрчилсэн загварын дагуу 15 хоногт багтаан төсөл хэрэгжүүлэх гэрээ(цаашид “гэрээ” гэх)-г байгуулна.
49. Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг энэ журамд өөрөөр заагаагүй бол буцалтгүй хэлбэрээр санхүүжүүлнэ.
50. Журмын 7.4-т хамаарах төслийн санхүүжилтийн шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад ноогдох хөрөнгийн хувь хэмжээг Сангаас санхүүжүүлнэ.
51. Төслийн зардал нь дараах бүрдэлтэй байж болно:
  - 51.1. судалгаа шинжилгээ, сорилт туршилтад шаардагдах материал, эм, урвалж бодис, туршилтын амьтан, нэг удаагийн хэрэглэгдэхүүн, сэлбэг хэрэгсэл худалдан авах зардал;
  - 51.2. эрдэм шинжилгээний хурлын зардал;
  - 51.3. судлаачдын оролцооны хувьд ноогдох цалин хөлс /төслийн зардлын 30 хувиас хэтрэхгүй байх/;
  - 51.4. гадаад, дотоод томилгоо, хээрийн судалгааны зардал;
  - 51.5. багаж, тоног төхөөрөмж, программ хангамж худалдан авах зардал;
  - 51.6. эрдэм шинжилгээ, патентын мэдээллийн санд хандах төлбөр;
  - 51.7. мэргэжлийн үнэлгээнд үндэслэн нийтэлдэг олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл нийтлүүлэх төлбөр;
  - 51.8. ашигтай загвар, патент мэдүүлэхэд гарах зардал;
  - 51.9. судалгааны үр дүнг түгээн дэлгэрүүлэх зардал /төслийн зардлын 2 хувиас хэтрэхгүй/;
  - 51.10. төслийн явц, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх зардал /төслийн зардлын 3 хувиас хэтрэхгүй/;
  - 51.11. дээж шинжүүлэх зэрэг бусдаар гүйцэтгүүлэх ажлын төлбөр;
  - 51.12. байгууллагын лабораторийн багаж, төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, явцын хяналт тавих, мэдээллийн сангаас мэдээлэл авах,

- сургалт зохион байгуулах зэрэг захиргаа, техникийн үйлчилгээний зардал /төслийн зардлын 5 хувьтай тэнцэх/
52. Энэ журмын 49.10-т заасан зардлыг төслийн гэрээ байгуулахад Шинжлэх ухаан, технологийн санд үлдээж, зарцуулна.
53. Төсөл хэрэгжүүлэхэд оруулсан хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон үндсэн хөрөнгийг төсөлдүүссаны дараа хэрхэн эзэмших талаар гэрээнд тусгасан байна.
54. Төсөл гүйцэтгэхэд олгож буй эрдэм шинжилгээний ажлын зардлыг зориулалтын бусаар зарцуулахыг хориглоно.
55. Эрдэм шинжилгээний ажлын зардлыг зөвхөн төслийн удирдагчийн зөвшөөрлөөр зарцуулна. Энэ талаарсанхүүжүүлэгч, гүйцэтгэгч, удирдагч нарын хооронд байгуулах гурвалсан гэрээнд тусгана.
56. Захиалагч, гүйцэтгэгчээс үл хамаарах шалтгаанаар санхүүжүүлэгч төслийн санхүүжилтийн хэмжээнд өөрчлөлт оруулах болсон тухай асуудлыг шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.
57. Санхүүжүүлэгч төслийн санхүүжилтэд оруулсан өөрчлөлтийн талаар захиалагч, гүйцэтгэгчид албан ёсоор мэдэгдэнэ. Энэхүү мэдэгдлийг үндэслэн захиалагч, гүйцэтгэгч төслийн үр дүнгийн даалгаварт өөрчлөлт оруулах бол нэмэлт гэрээ хийнэ.

### Зургаа. Төслийн хэрэгжилтэд хяналт тавих

58. Төслийг санхүүжүүлж эхэлснээс хойш дараагийн санхүүгийн жилийн эхний сард багтаан төслийн завсрын үр дүнгийн болон санхүүгийн тайланг захиалагч, санхүүжүүлэгчид тус бүр нэг хувийг ирүүлнэ.
59. Төслийн завсрын тайланд үнэлэлт дүгнэлт өгөх шинжээчийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно.
60. Төслийн завсрын үр дүнгийн тайланд захиалагч, шинжээч, санхүүгийн тайланд Шинжлэх ухаан, технологийн сан тус тус хяналт тавина.
61. Төслийн завсрын үр дүнгийн тайланд шинжээчээр 30 хоногийн дотор үнэлгээ хийлгэнэ. Завсрын үр дүнгийн тайланг “хангалттай” гэж үнэлсэн тохиолдолд дараа жилийн санхүүжилтийг олгоно.
62. Энэ журмын 55-т заасан бүрэлдэхүүн төслийн хэрэгжилтийн явцыг захиалагч, санхүүжүүлэгчээс үл хамаарах шалтгаанаар удаашрах, үр дүн нь гэрээнд заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд хугацаанаас өмнө гэрээг цуцлах, санхүүжүүлсэн хөрөнгийг гүйцэтгэгчээр нөхөн төлүүлэх талаар санал боловсруулан шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.
63. шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дор дурьдсан арга хэмжээ авна. Үүнд:
- 63.1. Төслийн завсрын тайлан нь үр дүнгийн болон санхүүгийн хувьд “хангалтгүй” гэж үнэлэгдсэн тохиолдолд төслийн хэрэгжилтийг зогсоож учирсан хохирлыг нөхөн төлүүлэх;

- 63.2. Төслийн завсрын тайлан нь үр дүнгийн хувьд “хангалтгүй”, санхүүгийн хувьд “хангалттай” гэж үнэлэгдсэн тохиолдолд санхүүжилтийг зогсоож, үр дүнг сайжруулах талаар хугацаатай даалгавар өгөх;
- 63.3. Төслийн завсрын тайлан нь үр дүнгийн хувьд “хангалттай”, санхүүгийн хувьд “хангалтгүй” гэж үнэлэгдсэн тохиолдолд санхүүгийн зөрчлийг арилгах хүртэл санхүүжилтийг зогсоох.
64. Төслийн завсрын тайланд үнэлэлт дүгнэлт өгөхтэй холбогдон гарах зардлыг энэ журмын 50-д заасны дагуу санхүүжүүлнэ.
65. Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болох оюуны өмчийг өмчлөх, ашиглах асуудлыг Инновацийн тухай хуулийн 27.1-д заасан журмаар зохицуулна.
66. Төслийн эрдэм шинжилгээний тайланг өмчлөх, ашиглах асуудлыг захиалагч, санхүүжүүлэгч, гүйцэтгэгч талууд төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэрээгээр зохицуулна.

## **Дөрөвдүгээр бүлэг. Эрдэм шинжилгээний ажлын үр дүн, түүнийг хүлээн авах, баталгаажуулах, мэдээлэх, тайлагнах**

67. Эрдэм шинжилгээний ажлын үр дүн нь дор дурдсан хэлбэртэй байж болно:
  - 67.1. нэг сэдэвт бүтээл, эрдэм шинжилгээний өгүүлэл;
  - 67.2. шинэ болон шинэчилсэн бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний загвар;
  - 67.3. шинэ болон шинэчилсэн технологи, технологийн ноу-хау;
  - 67.4. техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, түүний эд анги, туршилтын загвар, ажлын зураг;
  - 67.5. эмчилгээ, оношлогооны шинэ, дэвшилтэт арга, зөвлөмж, математик загвар, бодлогын алгоритм, программ хангамж;
  - 67.6. норм, норматив;
  - 67.7. малын шинэ үүлдэр угсаа, ургамлын шинэ сорт, шинэ эм, эмийн бүтээгдэхүүн, бэлдмэл, шинэ материал, шинэ бичил биетийн омог, ген, уураг;
  - 67.8. технологийн урсгалын шийдэл, технологийн автоматжуулалтын горим
68. Энэ журмын 67-д заасан үр дүнг дор дурдсан баримт бичгийн аль нэгээр баталгаажуулж, тайлагнана:
  - 68.1. мэргэжлийн үнэлгээнд үндэслэн нийтэлдэг олон улсын мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл;
  - 68.2. хэвлэгдсэн нэг сэдэвт бүтээл;
  - 68.3. шинэ бүтээлийн патент, олон улсын патент, патентийн мэдүүлэг;
  - 68.4. бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын гэрчилгээ;
  - 68.5. үндэсний болон олон улсын стандарт;
  - 68.6. захиалагч төрийн захиргааны төв байгууллагын шинжлэх ухааны зөвлөлийн дүгнэлт, хянан магадлагаа хийсэн комисс, эрдмийн зөвлөлийн хурлын дүгнэлт, хөндлөнгийн үнэлгээ;

69. Эрдэм шинжилгээний байгууллагын судалгааны үндсэн чиглэлийн эрдэм шинжилгээний ажлын тайланг үр дүнгийн гэрээгээр жил тутам тайлагнах бөгөөд 4 жилд тутамд нэгдсэн тайлангаа энэ журамд заасны дагуу баталгаажуулан шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүлээлгэж өгнө.
70. Төслийн удирдагч эцсийнтайланг хоёр хэлбэрээр боловсруулна.
- 70.1. төслийн үр дүн, санхүүжилтийн талаар зохих журмын дагуу бичсэн төслийн эцсийн тайланг захиалагчийн шинжлэх ухааны зөвлөлд хэлэлцүүлж, захиалагч, санхүүжүүлэгчид тогтоосон хугацаанд нь хүлээлгэн өгөх;
- 70.2. төслийн хүрээнд бий болсон шинжлэх ухааны шинэ мэдлэгийн талаар стандартын дагуу бичсэн эрдэм шинжилгээний ажлын тайланг хэвлэмэл болон цахим хэлбэрээрэнэ журмын 66-т заасан баталгаажуулах баримт бичгийн хамт Шинжлэх ухаан, технологийн санд төсөлдүүссанаас хойш 3 сарын дотор хүлээлгэн өгөх.
71. Энэхүү журмын 7.1, 7.2, 7.4-т хамаарах төслийн эцсийн тайланг гүйцэтгэгчээс хүлээн авснаас хойш 30 хоногт багтаан Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 2-т заасны дагуу үнэлэлт, дүгнэлт гаргуулна.
72. Захиалагч төслийн эцсийн тайланг шаардлагатай тохиолдолд шинжээч томилж хянан магадлагаа хийлгэнэ.
73. Гүйцэтгэгч нь төсөлдүүссанаас хойш 2 сарын дотор түүний үр дүнг захиалагчид актаар хүлээлгэж өгнө. Төслийн үр дүнг хүлээлгэн өгөхдөө шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Шинжлэх ухаан, технологийн төслийн үр дүнг үнэлж, хүлээн авсан акт”-ын үлгэрчилсэн загварын дагуу 4 хувь үйлдэж захиалагч, гүйцэтгэгч, санхүүжүүлэгч болон шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тус бүр нэг хувийг хадгалуулна.
74. Төслийн захиалагч-төрийн захиргааны төв байгууллагаас санхүүгийн эцсийн тооцоо хийх талаар санхүүжүүлэгчид хандсан хүсэлт, төслийн үр дүнг хүлээн авсан тухай захиалагчийн албан ёсны дүгнэлт болон төслийн эрдэм шинжилгээний ажлын тайланг Шинжлэх ухаан, технологийн санд хүлээлгэн өгсөн тухай актыг үндэслэн санхүүжүүлэгч материал хүлээн авснаас хойш 20 хоногт багтаан гүйцэтгэгчтэй эцсийн тооцоог хийнэ.

## Тавдугаар бүлэг. Хариуцлага

75. Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төв байгууллага эрдэм шинжилгээний байгууллагын судалгааны үндсэн чиглэлийн ажлын тайланг “хангалтгүй” гэж дүгнэсэн нь тухайн байгууллагын удирдлагыг үүрэгт ажлаас чөлөөлөх үндэслэл болно.

76. Гэрээнд заасан шаардлагыг хангаагүй гэсэн үндэслэлээр захиалагч төслийн эцсийн үр дүнг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд уг ажлыг дахин гүйцэтгүүлэх буюу санхүүжүүлсэн хөрөнгийг гүйцэтгэгчээр нөхөн төлүүлэх арга хэмжээг авна. Энэ тохиолдолд тухайн удирдагчийн төслийн сонгон шалгаруулалтад оролцох эрхийг 3 жил хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болно.
77. Төслийн гүйцэтгэгч энэхүү журмын 54,67, 68 дахь заалтад заасныг зөрчсөн тохиолдолд уг ажлын удирдагчийн төсөл удирдах эрхийг 3 жил хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ.
78. Төслийн гүйцэтгэлийн явц захиалагч, санхүүжүүлэгчээс үл хамаарах шалтгаанаар удаашрах, үр дүн нь гэрээнд заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд захиалагч, санхүүжүүлэгч нь хугацаанаас өмнө гэрээг цуцлах, санхүүжүүлсэн хөрөнгийг гүйцэтгэгчээр нөхөн төлүүлэх хүртэлх арга хэмжээ авна.
79. Гүйцэтгэгч, санхүүжүүлэгчээс үл хамаарах шалтгаанаар захиалагч төслийн завсрын болон эцсийн үр дүнгийн талаар гаргасан дүгнэлт, шийдвэрээ товлосон хугацаанд шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлээгүй бол захиалагчийн төсөл захиалах эрхийг 1 жилээр түдгэлзүүлнэ.
80. Захиалагч, санхүүжүүлэгч төслийг хугацаанаас нь өмнө зогсоох, санхүүжилтийг нөхөн төлүүлэх асуудлаар санал боловсруулан шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.
81. Энэ журмын 20, 22,23,24,25,26,35,36,46,56, 59, 61, 67, 68, 70, 76, 77-д заасныг зөрчсөн нь тухайн асуудлыг хариуцсан албан тушаалтантай хариуцлага тооцох үндэслэл болно.
82. Төсөл хэрэгжүүлэхтэй холбогдон үүссэн маргааныг шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хүлээн авч шийдвэрлэнэ. Хэрэв гомдол гаргагч энэхүү шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд асуудлаа шүүхэд тавина.